

**2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 11 дүгээр сарын 02-ны “Пүрэв” гарат e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын байр, чиг үүргийн давхардал, ажил үүргийн уялдаа холбооны талаарх дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар танилцуулах тул дүүрэгт хамаарах мэдээллийг олж авах, ЗТДГ-т ажлын байрны шинжилгээ хийх.	ТЗУХ
2	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хот, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд машин, тоног, төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж, нарийвчилсан тоон судалгааг яаралтай гаргаж танилцуулах. (2023.10.31-ний дотор)	ЗДО Б.Болормаа Багахангай тохижилт ОНӨААТҮГ
3	Дүүргийн хэмжээнд хичнээн км үерийн ус зайлуулах, далан, суваг, шуудууг хүчитгэх, засварлах, шинээр хийх шаардлагатай талаарх төсөв, тооцоо судалгааг гаргаж танилцуулах. (2023.10.31-ний дотор)	ЗДО Б.Болормаа ТХҮХ
4	Хот нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг машин, тоног, төхөөрөмжүүдийг нэгдсэн стандарттай болгох ажлыг шуурхай зохион байгуулах.	ЗДО Б.Болормаа ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
5	Нийслэлийн 2023 оны төсвийн тодотгол хийх бэлтгэл ажлыг сайтар хангаж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахтай холбогдуулан дүүргийн хэмжээнд нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай ажлуудыг танилцуулах.	ЗДО Б.Болормаа
6	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж, засварлан асалтыг 100 хувьд хүргэх, зам дээрх гэрэлтүүлгийн шонг яаралтай зайчлан, зөрчил гаргасан иргэнээр холбогдох төлбөрийг төлүүлэх.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
7	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, бүрэн бус тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаарх зөвлөмж, мэдээллийг иргэд, зорчигчдод хүргэж, хяналт тавих.	ЦХ-ийн Замын цагдаагийн хэсэг
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
8	УБЗАА-нд давс, бодисны төндэр зарлагдсантай холбогдуулан дүүргийн давс, бодисны нөөцөд дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг төлөвлөн хүргүүлэх.	ТХҮХ
9	Улаанбаатар-Чойр чиглэлийн А0101 улсын чанартай авто зам дагуу бусдын эзэмшлийн газарт удаан хугацаагаар зогсож, хог хаягдал, сольсон тос масло хаяж буй том оврын авто машинуудын асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгааг эрэлхийлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ТЗУХ, ЦХ, ГЗБА
10	Цас цэвэрлэгээний цагийн менежментийг зохицуулж, эхний ээлжинд тээврийн хэрэгслийн зорчих хэсэг болон замын тойрог хэсэг, явган замын хэсгийг цэвэрлэж ажиллах.	ЗДО Б.Болормаа Багахангай тохижилт ОНӨААТҮГ
11	Хадат хэсэгт байрлах худгаас усны шинжилгээ авах.	УСАТ
12	БНХАУ-ын Бугат хоттой хамтран ажиллах санамж бичиг	ЗДО Б.Болормаа,

	болон гэрээнээс эрх зүйн хувьд аль дээгүүрх баримт бичгийг сонгон боловсруулж, хамтын ажиллагааг эхлүүлэх.	ТЗУХ, Соёлын ордон
13	Дүүрэгт шашин номын үйлийг дэлгэрүүлэхтэй холбогдуулан “Бурхан багшийн их дүйчин өдөр”-ийг тохиолдуулан 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдах шашин урлагийн цэнгүүний арга хэмжээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцах.	НХХ, Соёлын ордон

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР